



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.5, 2.6, 2.7 дахь заалт, "Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийн 4.3 дахь заалт, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Г.Бүүвэйхүү	Менежментийн багийн Ахлах менежер
Т.Энхбаатар	Менежментийн багийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч
Б.Саруул	Менежментийн багийн Хуулийн асуудал хариуцсан ахлах шинжээч
Ц.Баттулга	Хяналт шалгалтын багийн Хянан шалгагч-референт
Т.Мөнгөнцэцэг	Хяналт шалгалтын багийн Хянан шалгагч, ахлах шинжээч

2.Ёс зүйн дэд хорооны даргыг гишүүдийн олонхын саналаар сонгон, нарийн бичгийн даргын чиг үүргийг ээлжлэн хэрэгжүүлэн, хуралдааны дэгийг баталж мөрдөхийг Ёс зүйн дэд хороонд даалгасугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Менежментийн баг (Г.Бүүвэйхүү)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ӨНӨРБАЯР

15160 0 1345

Боловсруулсан: *М. Энхбаатар*
Хянасан: *Б. Бувдсайхуу*
Хувь: *21.*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 дугаар сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.5, 2.6, 2.7 дахь заалт, "Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийн 4.3 дахь заалт, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Г.Бүүвэйхүү	Менежментийн багийн Ахлах менежер
Т.Энхбаатар	Менежментийн багийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч
Б.Саруул	Менежментийн багийн Албан хэрэг хөтлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
Ц.Баттулга	Хяналт шалгалтын багийн Хянан шалгагч-референт
Т.Мөнгөнцэцэг	Хяналт шалгалтын багийн Хянан шалгагч, ахлах шинжээч

2.Ёс зүйн дэд хорооны даргыг гишүүдийн олонхын саналаар сонгон, нарийн бичгийн даргын чиг үүргийг ээлжлэн хэрэгжүүлэн, хуралдааны дэгийг баталж мөрдөхийг Ёс зүйн дэд хороонд даалгасугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Менежментийн баг (Г.Бүүвэйхүү)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ӨНӨРБАЯР

Хянасан:
ХУУЛИЙН БАГИЙН
ЗӨВЛӨХИЙН АҮТОГ
Боловсруулсан:
ХУУЛИЙН БАГИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.АЗ

Ц.ХАЛИУНАА
/2024.12.13/

**Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын
Ёс зүйн дэд хороо байгуулах тухай
санал хураалтын танилцуулга**

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.1-т “Дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авсан, сондгой тооны гишүүнтэй байна.” гэж заасны дагуу Ёс зүйн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахтай холбогдуулан бүх албан хаагчдын хүрээнд Able программд санал хураалтын холбоосыг байршуулан цахимаар авсан.

• Санал хураалтын дүн болон оролцооны байдал:

1.Эхний санал асуулга: 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл хугацаанд санал хураалтыг цахимаар авахад нийт 40 албан хаагч санал хураалтад оролцсон ба санал хураалтын байдлыг багийн зөвлөх Азтай хэлэлцэн, дахин санал хураалтын ажлыг эхлүүлсэн.

2.Давтан санал асуулга: 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл хугацаанд санал хураалтыг цахимаар авахад нийт Нийт өссөн дүнгээр 48 албан хаагч санал хураалтад оролцож, өмнөх дүнгээс 8 албан хаагч нэмэгдэж оролцсон байна.

3. Давтан санал асуулга: 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаанд санал хураалтыг цахимаар авахад нийт Нийт өссөн дүнгээр 65 албан хаагч санал хураалтад оролцож, өмнөх дүнгээс 17 албан хаагч нэмэгдэж оролцсон байна.

• Санал хураалтын дүнгээр хамгийн олон санал авсан албан хаагчдыг харуулбал:

д/д	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Санал авсан тоо
1	Г.Бүүвэйхүү	Ахлах менежер	23
2	Б.Саруул	Албан хэрэг хөтлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	17
3	Т.Энхбаатар	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч	20
4	Ц.Баттулга	Хянан шалгагч, референт	15
5	Ц.Идэрбат	Хянан шалгагч, ахлах шинжээч	13
6	Ө.Манжил	Хянан шалгагч, референт	12
7	Т.Мөнгөнцэцэг	Хянан шалгагч, ахлах шинжээч	14

